**НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН**
**ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 06 сарын 27 өдөр Дугаар А/175 Улаанбаатар хот

Нийслэлийн ерөнхий боловсролын
Голомт сургуулийн данс бүртгэлд хөрөнгө
бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалт, 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалт Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эцэг, эх болон тус сургуулийн төгсөгчдөөс хандивласан нийт 5,888,000.0 (таван сая найман зуун наян найман мянга) төгрөгийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг хавсралтын дагуу данс бүртгэлд бүртгэн авахыг Нийслэлийн ерөнхий боловсролын Голомт сургууль (Р.Цэдэндамбаа)-д зөвшөөрсүгэй.

2.Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Нийслэлийн ерөнхий боловсролын Голомт сургууль (Р.Цэдэндамбаа)-д үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс /Г.Тэмүүжин/-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ В.ОЮУМАА

1150500637

D: lac \BL.Tushaal. doc

Нийслэлийн өмчийн харилцааны газрын даргын 2024 оны
06... дугаар сарын 27.ны өдрийн А/175 дугаар тушаалын хавсралт

## Бүртгэлд авах хөрөнгийн жагсаалт

*Байгууллагын нэр: Нииислэлийн ерөнхий боловсролын Голомт сургууль*

| № | Эд хөрөнгийн нэр | Марк дугаар | Үзүүлэлт | Ашиглалтанд орсон он | Чанар байдал | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Бүртгэлийн анхны үнэ | | Хөрөнгө оруулагч | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Нэгж | Нийт | Нэр | Эх үүсвэр |
| Машин тоног төхөөрөмж | | | | | | | 4 | | 3,100,000.0 | | |
| 1 | Принтер өнгөт олон үйлдэлтэй | Epson L3219, Ecotank | 4000-7500 page | 2024.05.28 | шинэ | ш | 1 | 1,680,000.0 | 1,680,000.0 | 10 жилийн ахмад төгсөгчид | Хандив |
| 2 | Ус цэвэршүүлэгч | Elko-BYCZ565 | 220V/50Hz –халуун-3л, хүйтэн-5л | 2024.05.28 | шинэ | ш | 2 | 570,000.0 | 1,140,000.0 | | |
| 3 | Ус цэвэршүүлэгч, баллонтой | Hyundai-BL-LB56 | Баллонтой, 50Hz | 2024.05.28 | шинэ | ш | 1 | 280,000.0 | 280,000.0 | 2024 оны төгсөгчид | |
| Тавилга, эд хогшил | | | | | | | 5 | | 2,788,000.0 | | |
| 4 | Шүүгээ төмөр хувцасны | 15 нүдтэй | Төмөр саарал, хар хүрээтэй | 2024.05.28 | шинэ | ш | 2 | 635,000.0 | 1,270,000.0 | Э.Энхням, 8-2 анги, эцэг, эх | |
| 5 | Төмөр сейф | 12 нүдтэй | Төмөр саарал, хар хүрээтэй | 2024.05.28 | шинэ | ш | 3 | 506,000.0 | 1,518,000.0 | 2024 оны төгсөгчид | |
| Нийт дүн | | | | | | | 9 | | 5,888,000.0 | | |